

ЗҮҮН БҮС НУТГИЙН ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ДХИС-ийн магистрант, хошууч Т.Баатархүү

Хураангуй: Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд хохирол, зардал багатай богино хугацаанд унтраах асуудал маш чухал бөгөөд сумын түвшинд уг үйл ажиллагаанд эхний ээлжид сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийнхан оролцдог. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуульд ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхийг заасан байдаг ч өнөөгийн байдлаар сумын мэргэжлийн ангийн оролцоо, багаж зэвсэглэмж нь учир дутагдалтай байна. Иймд ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үйл ажиллагааг сайжруулснаар түймэрт учирч болох хохирол, эрсдэлийг багасгах гол хүчин зүйл болж байна.

Түлхүүр үгс: Мэргэжлийн анги, ой, хээрийн түймэр.

Удиртгал

Ой, хээрийн түймрийн улмаас жилд дэлхийн ойн сангийн 1 хувь устдаг гэсэн тооцоо байдаг бөгөөд ой модны нөөцийн тал хувь нь сүүлийн 30 жилд устаж үгүй болсон. Иймээс ой хээрийн түймэр нь олон улсын түвшинд яригддаг томоохон эрсдэл билээ.

Хүн төрөлхтөн ой, хээрийн түймрийн хор хөнөөлтэй тэмцэх арга замыг эртнээс хайж, энэ талаар багагүй туршлага хуримтлуулсан гэж хэлж болохоор ч өнөөг хүртэл ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудал дэлхийн аль ч улс оронд бүрэн шийдэгдээгүй тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

Манай улсын хувьд хаврын хуурайшилтын үед ой хээрийн түймэр гарах нь ихэддэг. Ойн шатах материал, цаг агаарын нөхцөл байдал, гал гаргах эх үүсвэр гэсэн гурван нөхцөл бүрдсэн тохиолдолд түймэр гарч эхэлнэ. Монгол оронд хавар, намрын улирал, заримдаа хуурайшилт ихтэй зуны улиралд ой, хээрийн түймэр их, бага хэмжээгээр байнга тохиолдож байна. Ойн түймэр тохиолдох хамгийн идэвхжилтэй үе нь хавар 4,5 дугаар сар бөгөөд энэ үед жилийн бүх түймрийн 80 гаруй хувь нь гардаг. Харин намар 9,10 дугаар сард 15-18 хувь нь тохиолддог нь уур амьсгал, ургамал зүйн онцлогтой холбоотой.

Ой, хээрийн түймрийн гарах шалтгаанд байгаль цаг уурын нөхцөл байдлаас гадна хүний буруутай үйл ажиллагаа ихээхэн нөлөөлдөг бөгөөд манай орны газарзүйн онцлогоос шалтгаалж жилийн хур тунадасны хэмжээ бага, хаврын улиралд хуурайшилт их байдаг учир иргэдийн сонор сэрэмжгүй, хайнга үйлдэл асар их хохирлыг дагуулдаг билээ.

Ой, хээрийн түймрийн 10 тохиолдлын 9 нь хүний буруутай үйлдэл байдаг. Статистик үзүүлэлтээс харахад жилд дунджаар 3 сая га ой, хээрийн талбай түймэрт өртөж байгаагийн 80 орчим хувийг хээрийн талбай эзэлж байна.

Үндсэн хэсэг

Тал хээрийн түймрийн онцлог

Дорнод Монголын тал хээрийн экосистем, Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн төрөл зүйл болон нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулдаг хүчин зүйлүүдийн нэг бол гал түймэр юм.

Сүүлийн жилүүдэд Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын нутаг дэвсгэрт гардаг ой, хээрийн түймрийн тоо өсөж, давтамж ойртсоноос нийгэм, эдийн засаг, байгаль орчинд сөрөг нөлөө нь ихсэж байна.

Тал хээрт хүний хяналтаас гадуур тархан шатаж байгаа галыг хээрийн түймэр гэдэг. Тал хээр газар хур тунадас харьцангуй бага унадгаас хавар, намрын улиралд хуурайшилт ихтэй, хүчтэй салхитай байдаг учир түймэр маш их хурдацтай тархдаг онцлогтой.

Хээр тал нь нэг болон олон наст өвслөг бут, сөөг ургамал шатах материал ихтэй учраас түймрийн шаталтын эрч хүчийг тэтгэх аюултай байдаг. Салхины хурдаас шалтгаалан хавар хээрийн түймрийн тархах хурд нь 20-30 км/цаг зарим тохиолдолд 40-50 км/цаг хүрдэг юм.

Тал хээрийн түймэрт зөвхөн ургамлын нөмрөг шатаад зогсохгүй түймрийн фронтын дагуу хамгаалалтгүй байгаа айл өрх, өвөлжөө бууц, бэлтгэсэн өвс цахилгааны болон холбооны шон, мал сүрэг, ан амьтан шатах тохиолдол гардаг.

Салхины хүч ширүүсэх тусам их хэмжээний талбайг хамран шатаж байгаа түймрийн дөлний өндөр нь 1.0- 1.5 м хүрч маш халуун илч угаа гарах тул гар аргаар цохиж унтраах боломжгүй болдог. Салхины хурд 20 м/с их байх тохиолдолд агаарын босоо урсгалаар шатаж байгаа өвс ургамал, аргал хомоол 200 м түүнээс хол зайд шидэгдэж шинээр түймрийн голомт бий болдог онцлогтой⁵⁰

Гал түймрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө.

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2013-2022 онд гарсан ой хээрийн түймрийн судалгаа⁵¹

Зүүн бүсийн аймгуудад тохиолдсон ой, хээрийн түймрийн нэгдсэн мэдээ																	
д/д	Он	Тохиолдлын тоо	Хамарсан тоо			Нэрвэгдсэн хүн			Хорогдсон, устгасан мал, амьтан	Шалсан гэр, орон сууц, барилга	Шалсан талбай/м2/га/	Учирсан хохирол /сая.төг/	Заруулсан зардал /сая.төг-ээр/	Ажилласан хүч хэрэгсэл		Аварсан	
			аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн, хөрдсөн	Хүн						Техник	Хүн	Эд хөрөнгө /сая.төг/	
1	2022	87	3	29	0	0	0	75	7	574836.7	4391.3	72.03	2314	449	2	119.35	
2	2021	48	3	25	0	0	0	0	0	273666	2280.7	7343.8	2005	346	0	0	
3	2020	27	3	11	0	0	0	0	2	92202.556	1713.3	142.9	337	43	0	1275.3	
4	2019	46	3	5	0	0	0	0	3	576376.42	53729.273	66.878	4131	464	0	0	
5	2018	37	3	16	0	0	0	0	6	554465	2340.876	20.045	1094	177	0	0	
6	2017	84	3	20	0	0	0	0	12	50580.264	2541.875	86.723	928	150	0	0	
7	2016	85	3	5	9	3	6	3207	31	28526.8	5294.3	45.6	3583	458	0	0	
8	2015	138	3	9	25	0	25	12994	232	1993959.7	77870.2	251.3	13387	2145	0	0	
9	2014	43	1	0	11	1	10	3662	60	44940.1	1421.4	2291	655	45	0	0	
10	2013	69	1	0	2	2	0	24	9	32987.6	3533.3	444.5	3555	616	0	0	
Бүгд		664			47	6	41	19962	362	4222541.14	155116.524	10764.8	31989	4893	2	1394.65	

Зөвхөн 2015 онд Зүүн бүсийн 3 аймагт сүүлийн 10 жилд 664 удаа ой, хээрийн түймэр гарч, давхардсан тоогоор 120 сумын нутгийг хамран, ой, хээрт 4222541.14 га бэлчээр, 362 гэр, орон сууц, 19962 мал, ан амьтан, нас барсан 6, түлэгдэж, бэртэн 41, нийт 47 хүн түлэгдэж, бэртсэн, 155116.524 сая төгрөгийн хохирол гарч, түймэр унтраахад бензин шатахуун, хоол хүнс бусад бүгд 10764.8 сая төгрөгийн зардал гарсан байна. Түймэр унтраахад 31989 хүн, 4893 машин техник хамрагджээ.

Эдгээр тоо баримт, судалгаанаас үзэхэд гал түймэр нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хэчнээн их хор нөлөөтэй болох нь тодорхой харагдаж байна. Түймэр нь хүний амь нас, эрүүл мэндийг хохироож нөхөж баршгүй хохирол учруулдаг бөгөөд иргэд, малчдын

⁵⁰ Дорнод Монголын Биологийн төрөл зүйл төсөл (Сумын гал түймрийн менежментийн загвар) Чойбалсан хот 2002.

⁵¹ Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын ой, хээрийн түймрийн судалгаа 2023

гэр, байшин, хашаа, мал, үйлдвэрлэлийн барилга зэрэг өмч хөрөнгийг нь шатаан устгаж ядууралд оруулдаг нийгмийн ноцтой сөрөг үр дагавартай байдаг.

Малын бэлчээрийн өвс ургамал шатсанаас бэлчээрийн тэжээлийн нөөц хомсдож мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлдэг, харин байгаль орчинд түймрийн үзүүлэх нөлөөлөл нь сөрөг болон эерэг талуудтай байдаг гадаадын зарим орны туршлагаас үзэхэд хэт олон жил гал түймэр гараагүй тохиолдолд хур хагд өвс их хэмжээтэй хуримтлагдсанаас шатах материалын нөөц ихсэж, хэрэв түймэр гарвал унтраахад бэрхшээлтэй, хор хохирол ихтэй болдог тул зориуд хяналттайгаар тодорхой хугацаанд хэсэгчлэн шатаах арга хэмжээ авдаг байна.

Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан хүчтэй түймрийн үед ан амьтан түймэрт шатах, байршил нутгаасаа дайжих зэрэг сөрөг үр дагавар гардаг. Намар гарсан түймрийн улмаас мал сүрэг болон туурайтан амьтад ялангуяа цагаан зээр өвлийн бэлчээргүй болж тэжээлийн дутагдалд ордог.

Гал түймрийн өнөөгийн менежментийн сул талууд:

Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Мэргэжлийн ангийн дүрэм батлагдсанаар Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг суманд 66-аас доошгүй хүнтэй байхаар тусгаж өгсөн ч засаг захиргаа нутаг дэвсгэрийн үндсэн нэгж болох сум багийн түвшинд хараахан бүрэлдэж амжаагүй байна. Сумын хэмжээнд гал түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гарсан түймрийг шуурхай унтраах ажлыг зохион байгуулах уг асуудлыг сумын Засаг дарга, СОКомисс орон тооны бус байдлаар зохион байгуулж байна.

Сум багийн түвшинд гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөлт чанаргүй, хэн хэдийд юуг яаж хийх ёстойг сайн мэдэхгүй, энэ талаар тогтсон нарийн дэг журам дутагдалтай байна. Сумын ОК зарим үйл ажиллагааг төлөвлөдөг боловч түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа болох төсвийг төлөвлөж батлуулах асуудалд сул анхаарч иржээ.

Түймрээс урьдчилан сэргийлэх болон унтраах үйл ажиллагааны зардлыг төлөвлөөгүй, шатах тослох материал, хоол хүнс, ялангуяа гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах санхүүгийн эх үүсвэргүйгээс түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохих шаардлагын түвшинд хийхгүй, түймрийг эрт илрүүлж хохирол багатай шуурхай унтрааж чадахгүй байна.

Гарсан түймрийг шуурхай унтраах бэлтгэл, зохион байгуулалт хангалтгүйгээс цаг ихээхэн алдаж, түймрийг өргөжүүлэн газар авхуулж, аймаг сум дамжуулан алддаг, заримдаа хөрш зэргэлдээ улсын хилийг давуулдаг явдал гарсаар байна.

Сум багийн удирдлагууд түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулж, шаардлагатай хөрөнгө зардлыг гаргахгүй, түймэр нэгэнт гарсан хойно нь гэнэт ухаарч, унтраах үйл ажиллагаанд ихээхэн үргүй зардал гаргадаг явдал өнөөгийн гал түймрийн менежментийн сул талуудын нэг мөн.

Ой, хээрийн түймрээс хамгаалах тухай хууль тогтоомжуудаар хүлээсэн үүргийг нь аж ахуй нэгж, байгууллага, айл өрх, иргэн бүрд сурталчилж ойлгуулах, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд арилгуулах, зөрчил гаргагчидтай хариуцлага тооцож нийтэд ил тод мэдээлэх ажил зохих түвшинд хийгдэхгүй байна.⁵²

⁵² Дорнод Монголын Биологийн төрөл зүйл төсөл (Сумын гал түймрийн менежментийн загвар) Чойбалсан хот 2002.

Гал түймрийг хохирол багатай, шуурхай унтраах үйл ажиллагаа:

Гал түймэр унтраах үйл ажиллагаанд түймэр гарсныг илрүүлэхээс эхлээд түүнийг унтрааж дуусах хүртэл авсан бүх арга хэмжээ багтана. Түймэр гарсныг цаг алдалгүй илрүүлэн, хурдан мэдээлж, унтраах арга хэмжээг шуурхай зохион байгуулж чадсан эсэхээс түймэртэй тэмцэх ажлын үр дүн шалтгаалах ба ой, хээрийн түймрийг гарч байгаа эхний үед унтраах нь хамгийн хялбар байдаг.

Нэгэнт гарсан түймрийг хугацаа алдалгүй, цаг тухайд нь хурдан шуурхай илрүүлж, унтраах анхны арга хэмжээг багийн Засаг дарга, тухайн багийн малчид иргэдтэй хамтран авах ёстой.

Багийн Засаг дарга буюу хэсгийн ахлагч нь малчдынхаа нутаглаж байгаа байршлыг ойролцоо хариуцсан газар нутагт нь гарсан түймрийг түргэн шуурхай унтраах ажлыг эхлүүлэхийн хамт сумын онцгой комисст утсаар болон биеэр мэдээлэл өгнө.

Ой, хээрийн түймрийг унтраах ажлыг зохион байгуулж байгаа удирдагч нь түймрийн цагийн байдлыг тодорхойлон, үнэлэлт, дүгнэлт өгч, газар орны бартаа, зам, гол мөрөн, түймэр тархах чиглэл, гол хүчээ хаана байгуулах талаар шийдвэр гарган, түймэр унтраах хэсэг, бүлгүүдийг шуурхай оновчтой зохион байгуулж ажиллана.

Түймэр унтраах ажиллагааны үе шатууд

- Түймрийн тархалтыг зогсоох
- Түймрийг унтрааж цурамд оруулах
- Түймрийн цурав доторх галыг унтраах
- Түймрийн цурвын манаа

Түймрийн тархалтыг зогсоох. Ой, хээрийн түймрийн унтраахдаа салхины хүчнээс хамаарч унтраах аргыг сонгоно. Салхины хүч их бол асаж байгаа салхины чиглэлийн дагуу хажуу болон ар хэсгээс нь эхлэн цохиур буюу үлээгч аппарат, ус шүршигч ашиглан унтраах арга хэрэглэнэ.

Түймрийг унтрааж цурамд оруулах. Түймрийн цурмын захаар асаж байгаа цог нурмыг цэвэрлэж, цурмын гүн тийш шүүрдэх, цурмын захад ойр уугьж байгаа хожуул, хомоол, үндсийг ус болон шороогоор сайтар унтраах шаардлагатай.

Түймрийн цурав доторх галыг унтраах. Цурвын захад асаж байгаа мод, унанги мод зэргийг унтрааж шаардлагатай бол хөрөөдөж цурвын гүнд оруулан аюулгүй арга хэмжээг авч уугьж буй хомоол, үндэс, бут салхинд асаж түймэр дахин дэлгэрэх аюултай байдаг тул сайтар цэвэрлэж унтраах хэрэгтэй.

Түймрийн цурмын манаа. Ой, хээрийн түймрийн үед үндэс, хомоол, хожуул, хөрсөн доогуур асч, түймрийн цурамын гадна талд шинээр цурам үүсэх, мөн шатаж байгаа мод унаж шинээр түймэр гарах зэрэг шалтгаанаар дахин дэлгэрдэг тул 3-8 хоногоор харуул манаа гаргах нь дахин түймэр гаргахгүй юм⁵³.

⁵³ А.Бадамдорж. Ой, хээрийн түймрийг унтраах арга зүйн зарим асуудал (Дорнод аймгийн жишээн дээр) 2015



Хээрийн түймэрт гарч байсан алдаа дутагдал, ололттой талуудыг сум орон нутаг болон Онцгой байдлын газрын түймэрт ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, томилолт, цалин хөлс, шатахуун, хоол хүнс, орон нутгийн газар зүйн байршил, онцлогт харьцуулалтын аргаар дүн шинжилгээг хийсэн болно. Дээрх харьцуулалтын арга дээр мөн ахуйн гал түймрийн чөлөөт шаталга, хүрэлцэн очих хугацааг тооцож гаргадаг аргачлалын дагуу хээрийн түймрийн чөлөөт шатлагийн дундаж хугацааг тооцож гаргасан. Уг тооцооноос ой, хээрийн түймрийг богино хугацаанд унтраахад зарцуулах зардал, хохирлыг багасгах нь сумын мэргэжлийн ангийн чадавхтай холбоотой гэдгийг харж болно.

ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ЧӨЛӨӨТ ШАТЛАГЫН ТООЦОО

$$t_{ч.ш} = t_m + t_{ц.т} + t_{бб} + t_o$$

$t_{ч.ш}$ = чөлөөт шатлага

t_m = Мэдээ авах, өгөх хугацаа

$t_{ц.т}$ = Яаралтай цуглар дохиогоор ажиллах хугацаа

$t_{бб}$ = Бэлэн байдал хугацаа

t_o = Замд явах хугацаа

Тайлбар:

t_m = 1. Хяналтгүй шатах шатлагын процесс /10-30мин/ 15^1

2. хэн нэгэн харсан /5-10мин/ 5^1

3. утасны сүлжээтэй /2-5мин/ 3^1

4. утасны сүлжээгүй

5. морьтой тодорхой зайнаас хамаарч /5-20мин/ 10^1

5. техник хэрэгсэлтэй /5-10мин/ 5^1

t_m = түймрийг анх харсан иргэн 1+2+3 бол = 23мин

түймрийг анх харсан иргэн 1+2+4 бол 30мин

түймрийг анх харсан иргэн 1+2+5 бол 25мин

дундаж хугацаа 25 мин

Мэдээг сум, аймаг орон нутгийн удирдлага

Онцгой байдлын газарт мэдээлэх

$t_{ц.д}$ - Цуглар дохиогоор ажиллах хугацаа

$t_{дха}$ - ОБГ-н Дуудлага хүлээн авагчид мэдээлэх хугацаа

$t_{обг}$ удирдлага - Дуудлага хүлээн авагчаас ОБГ-н удирдлагуудад танилцуулах хугацаа

$t_{с/захирагч}$ - ОБГ-н түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах ангиудад ЯЦ дохиогоор цугларах мэдээлэл хүргэх хугацаа

$t_{с/т}$ ЖАГСАХ- ЯЦ дохиогоор ирсэн салаа, бүлгийн алба хаагчид жагсаж үүрэг чиглэл авах.

$$t_{ц,д} = t_{дха} + t_{обг \text{ удирлага}} + t_{с/захирагч} + t_{с/т \text{ ЖАГСАХ}}$$

тайлбар:

1. $t_{дха}$ = мэдээллийг хүлээн авах
2. удирдлагад танилцуулах /2-4мин/ 3 мин
3. С/захирагч нар \longrightarrow ЯЦ зарлах \longrightarrow /15-30мин/ 15 мин
4. Салаа, тасаг жагсах /5-10мин/ 5 мин

$$t_{ц,а} = 3 \text{ мин} + 3 \text{ мин} + 15 \text{ мин} + 5 \text{ мин} = 26 \text{ мин}$$

Дундаж хугацаа 26 мин

$$t_{б.б} = t_{б/зэв} + t_{ХАБ \text{ Заавар}} + t_{автомашин \text{ шат}}$$

$t_{б/зэв}$ - автомашинд гал унтраах багаж зэвсэглэмж ачиж байршуулах /5-8мин/ (6мин)

$t_{заавар}$ - алба хаагчдад ХАБЭАД-н зааварчилгаа өгөх /5-10мин/ (7мин)


$t_{шат}$ - автомашин шатахуун цэнэглэх /5-10мин/ (8мин)

$$t_{в.в} = 6 \text{ мин} + 7 \text{ мин} + 8 \text{ мин} = 21 \text{ мин}$$

дундаж хугацаа 21 мин

$$t_{ч.ш} = t_{м} + t_{ц,т} + t_{б.б} + t_{о}$$

$$t_{ч.ш} = 25 \text{ мин} + 26 \text{ мин} + 21 \text{ мин} + 188 \text{ мин} = 260 \text{ мин} = 4 \text{ цаг } 20 \text{ мин}$$



$$T_{о} = \frac{220 \text{ км} / \text{ц.60}}{70 \text{ км} / \text{цаг}} = 188 \text{ мин}$$

ОБГ Шуурхай албаны автомашины хүрэлцэн очих хугацаа

Сумаас мэргэжлийн анги, дайчилгаа, иргэдийн бүлэг хүрэлцэн очих хугацаа

$$T_{о} = \frac{40 \text{ км} \cdot 60}{70 \text{ км} / \text{цаг}} = 34 \text{ мин}$$

Сумаас мэргэжлийн ангийн бүлэг хүрэлцэн очих хугацаа

$$t_{ч.ш} = t_{м} + t_{ц,т} + t_{б.б} + t_{о}$$

$$t_{ч.ш} = 25 \text{ мин} + 26 \text{ мин} + 21 \text{ мин} + 34 \text{ мин} = 106 \text{ мин} = 1 \text{ цаг } 46 \text{ мин}$$

Харьцуулалт - Сумын давуу тал:

1. Хүрэлцэн очих хугацаа бага.
2. Газар орноо мэднэ./гол, нуур цөөрөм, зам, уул хад, жалга дов, бэлчээр г.м/

- 3.Хоол хүнс хангагдах боломжтой.
- 4.Айл өрх, өвөлжөө, гэх мэт аварч гаргах айл, өрх, мал амьтан мэддэг.
- 5.Ажиллах хүн хүч ихтэй.

Сумын дутагдалтай тал:

- 1.Багаж зэвсэглэмж байхгүй. /цөөн тооны/
- 2.Тусгай автомашин байхгүй.
- 3.Цалин хөлс, урамшуулал байхгүй.
- 4.Аюулгүй байдлыг хангах тусгай хувцас хэрэглэл байхгүй.

Аймгийн Онцгой байдлын газрын давуу тал:

- 1.Тусгай автомашин, багаж зэвсэглэмжтэй /үлээгч аппарат, рло, цуравдагч, цохиур, тросон шүүр г.м/
- 2.Сансарын болон үүргэвчин холбооны хэрэгсэлтэй./ириудум/

Аймгийн Онцгой байдлын газрын дутагдалтай тал:

- 1.Хүрэлцэн очих хугацаа их зарцуулдаг.
- 2.Газар орон мэдэхгүй.
3. Шатахууны хомсдолтой.
- 4.Хоол хүнс байхгүй.
- 5.Ажиллах хүн цөөхөн./1 бүлэг 12 хүнтэй/

Дээрх харьцуулалтын аргаас харахад сумын мэргэжлийн ангийн дутагдалтай талыг сайжруулахад ой, хээрийн түймрийг цаг алдалгүй хохирол багатай унтраах нөхцөл бүрэн байна гэж харж болохоор байна.

Дүгнэлт

Иймд сургалт явуулан олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх замаар урьдчилан сэргийлэх, орон нутгийн түвшинд мэдээлэл солилцоог боловсронгуй болгож хяналтгүй түймэр тархах эрсдэлийг бууруулах, хамтын ажиллагааг сайжруулах, түймрийн аюулыг арилгах техникийн хангамжийг сайжруулах, ой хээрийн түймрийн гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Дорнод Монголын Биологийн төрөл зүйл төсөл (Сумын гал түймрийн менежментийн загвар) Чойбалсан хот 2002.
2. Мэргэжлийн ангийн дүрэм 2017.
3. Гамшгаас хамгаалах тухай хууль 2017.
4. Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын ой, хээрийн түймрийн судалгаа 2023.
5. А.Бадамдорж. Ой, хээрийн түймрийг унтраах арга зүйн зарим асуудал (Дорнод аймгийн жишээн дээр) 2015.